


Цацраг идэвхт ашигт малтмалын олборлолт, боловсруулалтын технологи, зах зээл, төлөв байдлын талаарх үндэсний болон олон улсын мэдээлэл

Монгол орны нутаг дэвсгэрт цацраг идэвхт ашигт малтмалын 13 орд, 100 орчим илрэл, 1000 гаруй эрдэсжсэн цэг, цацраг идэвхт гажил илрүүлсэн.

АМГТГ-аас 2022 оны 06 дугаар сарын байдлаар авсан мэдээллээр Монгол Улсад ураны 13 ордын хэмжээнд 192,241.02 тонн геологийн нөөц бүртгэн авсан. Нийт нөөцийн 67% нь ГДУО ашиглахад тохиромжтой.




Зураг 1. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн бүртгэгдсэн цацраг идэвхт ашигт малтмалын геологийн нөөц

Монгол Улсын хэмжээнд 2022 оны 06 дугаар сарын байдлаар 4 аймгийн 10 сумын нутагт нийт 132.7 мянган гектар талбайд цацраг идэвхт ашигт малтмалын чиглэлээр хайгуулын 5, ашиглалтын 8 тусгай зөвшөөрлийг 7 аж ахуйн нэгж эзэмшиж байна.

2. Дэлхийн ураны олборлолтын талаар:


Дэлхийн хэмжээнд 2021 оны байдлаар 48.3 мянган тонн уран олборлосон бөгөөд БНКаЗУ дангаараа 21.8 мянган тонн уран олборлож, дэлхийн ураны олборлолтод тэргүүлэх байр суурь эзэлсэн хэвээр байна. Нийт уран олборлолтын 66%-ийг 3 улс буюу БНКаЗУ (45%), Намиб (12%), Австрали (9%) улсууд тус тус олборлосон байна.



Зураг 2. Дэлхийн уран олборлолтын хэмжээ

Ураныг уламжлалт уурхайн арга (ил, далд уурхай)-аар олборлож байсан боловч шинжлэх ухаан, технологийн дэвшилтэй уялдан уран олборлох технологид өөрчлөлт гарч,

газрын дор уусган олборлох технологи үйлдвэрлэлд эрчимтэй нэвтэрч байна. 1990 онд нийт олборлосон ураны 55%-ийг далд уурхайн аргаар олборлож байсан бол 2021 онд нийт ураны 66%-ийг газрын дор уусган олборлох аргаар, 29%-ийг уламжлалт уурхайн аргаар, үлдэх хэсгийг дайвар бүтээгдэхүүн хэлбэрээр тус тус олборложээ.



Зураг 3. Уран олборлох уурхайн аргуудын ашиглалт (2021 оны байдлаар)


2021 оны байдлаар дэлхийн нийт уран олборлолтын 85%-ийг дараах 10 компани бүрдүүлжээ.

Хүснэгт 1. Уран олборлолтоор тэргүүлэгч компаниуд (2021 оны байдлаар)

№	Компани	Улс	Уран (тонн)	Эзлэх хувь
1.	Казатомпром	БНКазУ	11,858	25
2.	Орано	БНФУ	4,541	9
3.	Ураниум Ван	ОХУ	4,514	9
4.	Камеко	Канад	4,397	9
5.	Си Жи Эн	БНХАУ	4,112	9
6.	Навой Майнинг	Узбекистан	3,500	7
7.	Си Эн Эн Си	БНХАУ	3,562	7
8.	Рио Тинто	Австрали, Англи	3,021	6
9.	АРМЗ	ОХУ	2,635	5
10.	Женерал Атомикс/Куазар	АНУ	2,241	5
11.	Би Эйч Пи	Австрали	1,922	4
12.	Энержи Азия	Япон	900	2
13.	Сопамин	Нигер	809	2
14.	ВостГок	Украин	455	1
	Бусад		2,857	6
	Нийт		48,303	100

4. Дэлхийн ураны нөөц, үнэ, зах зээлийн судалгаа:

ОУАЭА, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-ын Цөмийн энергийн агентлаг хамтран 2 жил тутам гаргадаг ураны олборлолт, эрэлт, нийлүүлэлтийн талаар “Улаан ном” тайлангийн 2020 оны хэвлэлд нэг килограмм ураныг 260 хүртэлх ам.долларын өртгөөр олборлох боломжтой 8.1 сая тонн, 130 хүртэлх ам.долларын өртгөөр олборлох боломжтой 6.1 сая тонн ураны нөөц тус тус байна гэж бүртгэжээ.



Зураг 4. Дэлхийн ураны нөөцийн тархалт

Дээрх нөөцийн 95% нь зурагт харуулсан 15 оронд ногдож байгаа бөгөөд үлдэх 5% нь дэлхийн 22 улсад ногддог. Монгол Улсын ураны нөөц дэлхийн ураны нөөцийн 2%-ийг бүрдүүлж байна.

Шар нунтгийн үнэ

Дэлхий нийтээрээ цэвэр эрчим хүчний үйлдвэрлэл, нүүрстөрөгчийн ялгаруулалтыг бууруулж, урт хугацааны найдвартай эрчим хүчний эх үүсвэр рүү шилжиж байгааг харгалзан ураны нийлүүлэлт нь дэлхийн хэмжээнд чухал болж байна. Хэдийгээр 2025 он хүртэл реакторын шаардлага харьцангуй жигд байх боловч 2026-2035 он хүртэл эрэлтийн мэдэгдэхүйц өсөлт байгаа нь ураны хэд хэдэн төслийн нөөц шавхагдаж байгаа тул шинэ үйлдвэрлэлүүдийг шаардах үе байх болно.

Хэдийгээр 2021 онд хоёрдогч нийлүүлэлт 33%-ийг эзэлсэн ч, 2050 он гэхэд мэдэгдэхүйц буурч нийлүүлэлтийн 19%-д хүрч, 2030 он гэхэд нийт нийлүүлэлтийн 11%-д хүрэх төлөвтэй байна. Ураны нийлүүлэлтийн алдагдал эрэлттэй харьцуулахад 2027 он хүртэл хамгийн бага байх төлөвтэй байгаа бөгөөд ураны үйлдвэрлэл ашиглалтын хүчин чадалдаа хүрээгүй уурхайнуудыг дахин эхлүүлэх, хүчин чадалд нь хүргэснээр нэмэлт хомсдлыг нөхөх магадлалтай боловч UxC-ийн тооцоолсноор 2027-2035 оны хооронд ураны шинэ төслүүд нэмж хэрэгжих нэн шаардлагатай харагдаж байна. Одоо олборлолт хийж буй уурхайнуудын нөөц шавхагдаж, үндсэн эрэлт нэмэгдсэнээр урамшууллын үнэ тогтоох шаардлага гарч болзошгүй байна гэжээ.

Дэлхийн Цөмийн Нийгэмлэг (WNA)-аас гаргасан “Цөмийн түлшний тайлан: 2021-2040 он хүртэлх эрэлт, нийлүүлэлтийн дэлхийн хувилбарууд”-д ирэх 20 жилд цөмийн үйлдвэрлэлийн хүчин чадал жил бүр 2.6%-иар өсөж, 2040 онд 615ГВт болох төлөвтэй байна. Эдгээр реакторуудын түлшинд 2021 онд 62,500 тонн уран байсан бол 2030 онд ойролцоогоор 79,400 тонн уран шаардлагатай, 2040 онд 112,300 тонн уранд хүрэх төлөвтэй байна.


Ураны үнийг өсгөх зорилгоор ураны томоохон үйлдвэрлэгчид үйлдвэрлэлээ бууруулсан, мөн ковид-19 цар тахлын улмаас нийлүүлэлт саарч 2020 оноос ураны үнэ өсөж эхэлсэн.

Казахстаны Казатомпром, Канадын Камеко зэрэг томоохон үйлдвэрлэгчид нийлүүлэлтээ танаж, Sprott Physical Uranium Trust сангууд үүсгэн байгуулагдсаны дараа ураны үнэ огцом өсөж 2021 оны 09 дүгээр сард түүхэн өсөлт болж, 1 фунт нь 50 ам.долларт

хүрсэн бөгөөд арван жил орчим үргэлжилсэн уналтын дараа 2021 онд ураны үнэ тодорхой хэмжээгээр эерэг болсон.

2022 гарснаар Казахстаны дотоодын үймээн болон ОХУ, Украйны асуудалтай холбоотойгоор Европын холбоо ОХУ-аас нүүрс импортлохоо зогсоох шийдвэр гаргаж, АНУ нь ОХУ-аас цөмийн түлш импортлохыг хориглох тухай хуулийн төслийг Конгрессын танхим болон Сенатад өргөн барьсны дараа ураны зах зээлийн үнэ 2022 оны 04 дүгээр сард 2011 оны Фукушимогийн ослоос хойшхи хамгийн өндөр түвшин буюу 1 фунт нь 64.5 ам.долларт хүрсэн.

Улс орнууд нүүрстөрөгчийн төвийг сахисан болон ОХУ-аас эрчим хүчний түүхий эдийн тээвэрлэлтийг хязгаарласнаас үүдэж цөмийн түлшний эрэлт нэмэгдэж байгаатай холбоотойгоор үнэ аль хэдийн өссөөр байна. Түүнчлэн ОХУ-аас цөмийн түлш авахыг хориглосон нь барууны орнуудын уран хувиргагч, баяжуулагчийн эрэлтийг нэмэгдүүлж, энэ нь баяжуулах үйлдвэрүүдийн одоогийн хүчин чадлаас давсан байна. 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар 1 фунт ураны зах зээлийн үнэ 47.35 ам.доллар байна.



source: tradingeconomics.com

Зураг 6. Шар нунтагийн 2021.12 – 2022.06 сарын байдлаарх үнэ